

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 5 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2011-4 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-5 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	140	9 ¹		149
3	Даатгалын төлөөлөгч	1592	246 ²		1838
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	7			7
6	Актуарч	12			12
7	Бусад				

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-д Өмнөговь аймгийн Даланзадгад сум, “Номин даатгал” ХХК-д Увс аймгийн Улаангом сум, Ховд аймгийн Жаргалант сум, Нийслэлийн Багахангай дүүрэгт, “Монгол даатгал” ХХК-д Нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт, 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар “Мөнх даатгал” ХХК-д Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Орхон аймгийн Эрдэнэт хот, Өмнөговь аймгийн Даланзадгад суманд даатгалын салбар нээн ажиллуулахыг тус тус зөвшөөрсөн.

²Хорооны даргын 2011 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 81 дүгээр тушаалаар “Практикал даатгал” ХХК-ийн 78 төлөөлөгчид, 2011 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 91 дүгээр тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 97 төлөөлөгчид, “Бодь даатгал” ХХК-ийн 71 төлөөлөгчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 5 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-5 сар	2011-5 сар

1	Даатгалын нийт хураамж	2,368,975,454.0	3,305,616,507.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	529,852,597.5	729,637,840.2
3	Давхар даатгалд төлсөн хураамж	52,103,618.8	120,484,820.6
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	21,395	22,096
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	25,818,851,639.0	12,202,026,062.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	40,000,000.0	82,988,000.0

2011 оны 5 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 936.6 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 1,571.5 сая төгрөгөөр буурч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 199.8 сая төгрөгөөр, урд сарынхаас 87.6 сая төгрөгөөр тус тус өссөн, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 68.4 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 809.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниудын олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 5 сарын байдлаар дараах графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Тайлант үед даатгалын компаниуд 120.5 сая төгрөгийг давхар даатгалд шилжүүлснээс 73.2 хувь буюу 88.2 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 23.5 хувь буюу 28.3 сая төгрөгийг “Практикал даатгал” ХХК, 2.8 хувь буюу 3.3 сая төгрөгийг “Миг даатгал” ХХК, 0.5 хувь буюу 0.6 сая төгрөгийг “Тэнгэр даатгал” ХХК тус тус шилжүүлсэн байна.


Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-5 сар	2011-5 сар
1	Даатгалын нийт хураамж	6,293,110.9	41,858,181.9
2	Олгосон нийт нөхөн төлбөр	3,900,728.0	4,775,458.0

3	Давхар даатгалд төлсөн хураамж		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	9	66
	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	8	15
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	4
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		1
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		10
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		19
	-Тэтгэврийн даатгалд		17
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,000,000.0	31,695,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	760,000.0	407,550.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 5 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 35.6 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 0.9 сая төгрөгөөр тус тус өсч, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн хэмжээ 10.6 сая төгрөгөөр өсч, даатгалын нөхөн төлбөр 1.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн олсон даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 5 сарын байдлаар дараах графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-3 сар	2011-4 сар	2011-5 сар

1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	67,806,527.4	33,494,569.7	94,822,540.8
2	Даатгалын зуучлагчийн орлого	26,375,510.9	11,945,725.9	35,469,420.0
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	44	81	93
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	6,261,150,000.0	1,000,000,000.0	3,000,000,000.0

2011 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 93 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 35.5 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-3 сар	2011-4 сар	2011-5 сар
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	2,999,772.7	3,901,790.9	4,173,500.0
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	225	191	211
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	33,160,000.0	69,407,178.0	16,591,000.0

2011 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 211 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж, 4.2 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсэн орлоготой ажиллажээ.